



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

233.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай	1018
234.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	1019
235.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	1019
236.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1020

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

237.	Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 38	1021
238.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 39	1021

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

239.	Нэрэмжит тэтгэлгийн журам шинэчлэн батлах тухай	Дугаар 111	1022
240.	Улаанбаатар хотын цагдаагийн газар байгуулах тухай	Дугаар 115	1028
241.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 121	1028
242.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 129	1029
243.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 130	1031



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2015 он	2016 он	2017 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	10.2	7.0	5.9
2	Хэрэглээний үнийн индексийн түвшин	7.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,201.1	7,322.2	7,793.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	29.4	26.5	25.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,690.9	7,874.9	8,400.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.4	28.5	27.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт /тэрбум төгрөг/	378.5	184.0	525.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.5	0.7	1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-489.8	-552.7	-607.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,967.3	2,026.3	2,127.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.0	7.3	7.0
8	Улсын ерийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	9,796.5	11,054.6	12,154.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	40.0	40.0	40.0



9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	272.8	285.8	298.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.1	1.0	1.0

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн



үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 06 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.2, 40.3 дахь хэсэг нэмсүгэй:

“40.2.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.1-11.2.3-т заасан салбарын улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчийн тухайн төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.

40.3.Энэ хуулийн 40.2-т заасан улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээг Засгийн газар тогтооно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, түүнийг дагалдсан “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тайлан, Засгийн газрын баталгаа гаргасан үнэт цаасны хөрөнгөөр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний



тайланг Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийн хамт Улсын Их Хуралд тус тус танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 111

Улаанбаатар
хот

Нэрэмжит тэтгэлгийн журам шинэчлэн батлах тухай

Боловсролын тухай хуулийн 43.2.9 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Амжилттай сурч хөдөлмөрлөн үлгэр жишээ болохуйц онцгой амжилт гаргасан шилдэг оюутанд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг 1 дүгээр, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг”-ийн загварыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нэрэмжит тэтгэлгийн журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 46 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

Засгийн газрын 2014 оны 111 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ШИЛДЭГ ОЮУТАНД МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН ЕРӨНХИЙ САЙДЫН
НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Мэдлэг боловсрол, бүтээлч чанар, шинэ санаа, сайн үйлс, авъяас, ур чадварыг хөгжүүлэх, урамшуулан дэмжих зорилгоор үлгэр жишээ онцгой амжилт гаргасан дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын хөтөлбөрийн өдрийн ангийн оюутан, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв (цаашид “сургууль” гэнэ)-ийн суралцагч (цаашид “суралцагч” гэнэ)-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэнэ) олгоход энэхүү журмыг баримтална.

1.2 Дараах шалгуур үзүүлэлтүүдийг 50-иас дээш хувьтай хангасан суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг олгоно.

Үүнд:

1.2.1. хичээлийн жилийн 4 улирал дараалан голч дүн нь 3.6-аас доошгүй үнэлэгдсэн байх;

1.2.2. нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцож, зохион байгуулж, олон нийтэд мэдээлэгдсэн байх;

1.2.3. суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээрээ олон улсын болон үндэсний хэмжээнд судалгаа хийж үнэлүүлсэн, шинэ санаа, үр дүнг хэвлэн нийтлүүлсэн, техник технологийн ололт амжилтыг хэрэглээнд нэвтрүүлсэн байх;

1.2.4. монголын уламжлалт ёс заншил, угийн бичиг хөтлөх болон бусад үйл хэргийг өөрийн амьдралдаа хэвшүүлэн дадлагажуулж бусдад үлгэрлэсэн байх.

1.3. Дараах шалгуур үзүүлэлтийг 50-иас дээш хувьтай хангасан суралцагчид Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгоно.



Үүнд:

1.3.1. Монгол Улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр (2014 оны 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан) үр ашиг, ач холбогдол бүхий шинэ технологи, бүтээгдэхүүн, материал бий болгон үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх шинэ санаачилга гаргасан байх;

1.3.2. сайн санааны үндсэн дээр нийгмийн сайн сайхны тусын тулд бусдыгаа манлайлан идэвхи зүтгэл гаргаж үлгэр жишээ болохуйц ажлыг санаачлан зохион байгуулсан, зэрэг өөрчлөлтөөр бусдадаа үлгэр дуурайл болсон байх;

1.3.3. монгол хэл, соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулан түүнийг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлсэн байх;

1.3.4. суралцаж байгаа мэргэжлээрээ амжилттай суралцаж бусдад үлгэр дуурайл болсон, улс орны хөгжилд зэрэг үр нөлөө үзүүлэхүйц судалгаа, шинжилгээний бүтээл туурвисан, оновчтой үр дүнтэй бодлого төлөвлөгөө, зөв шийдэл, арга барил бүхий нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл, хөтөлбөр санаачлан бичиж хэрэгжүүлсэн;

1.4. Тэтгэлгийн болзол хангасан 30 хүртэлх суралцагчид жил бүр Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын үсэг бүхий өргөмжлөл, мөнгөн шагнал болох 1.200.000 төгрөг олгоно.

1.5. Тэтгэлгийн болзол хангасан 40 хүртэлх суралцагчид жил бүр Монгол Улсын Ерөнхий сайдын гарын үсэг бүхий өргөмжлөл, мөнгөн шагнал болох 1.000.000 төгрөг олгоно.

Хоёр. Материал хүлээн авах, шалгаруулалт

2.1. Энэхүү журмын 1.2, 1.3 -т заасан болзлыг хангасан оюутан өөрөө буюу сургуулийн захиргаа, оюутны байгууллага нь хамтарч тухайн суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлнэ.

2.2. Тэтгэлэгт нэр дэвшигчийн дор дурдсан бичиг, баримтыг жил бүрийн 4 ба 11 дүгээр сарын 15-ны дотор сургуулийн оюутны холбоо нь шалгаруулж, болзол хангасан оюутнуудын материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ:



2.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг (2 дугаар хавсралт);

2.2.2. энэхүү журмын 1.2.1, 1.3.4-т заасан болзлыг хангасан суралцагч нь сурлагын амжилт, ур чадвараа баталгаажуулсан сургуулийн захиргааны болон оюутны холбооны тодорхойлолт, гэрчилгээ, батламжийн хуулбар, бичиж хэрэгжүүлсэн төслийн үр дүнгийн тухай танилцуулга;

2.2.3. энэхүү журмын 1.2.3, 1.3.1-д заасан болзлыг хангасан суралцагч нь хэвлүүлсэн илтгэл, өгүүллийн хувь, медаль, шагнал, өргөмжлөл, гэрчилгээ, патент болон тухайн шинэ технологи, бүтээгдэхүүн материалыг хүлээн зөвшөөрсөн салбарын эрх бүхий байгууллагын шийдвэрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.2.4. энэхүү журмын 1.2.2, 1.3.2-т заасан болзлыг хангасан суралцагч нь холбогдох арга хэмжээ, олон нийтийн ажлыг хамтран зохион байгуулсан байгууллагын тодорхойлолт, тухайн арга хэмжээний зорилго зорилт, үр дүнгийн талаар холбогдох мэдээлэл, дүрс бичлэг, фото зураг;

2.2.5. энэхүү журмын 1.2.4, 1.3.3-т заасан болзлыг хангасан суралцагч нь хадгалан хамгаалж, өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлж байгаа уламжлалт ёс заншил, ургийн бичиг, соёлын биет болон биет бус өвийн талаархи богино хэмжээний танилцуулга, дуут ба дүрс бичлэг, түгээн дэлгэрүүлж байгааг нотлох бусад материалууд;

2.2.6. тухайн нэрэмжит тэтгэлгийн болзлыг хангасан талаар оюутан өөрөө 500 үгэнд багтаан эссэ бичиж ирүүлнэ.

2.3. Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсэг гаргаж, шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулна.

2.3.1. ажлын хэсэг нь 1 дүгээр шатанд ирүүлсэн материалыг үнэлэн 50 хүртэлх оноо, 2 дугаар шатанд бичиж ирүүлсэн эссэг үнэлэн 50 хүртэлх оноог өгч, 2 шатны нийлбэрээр 85-100 оноотой суралцагчийг шалгаруулан Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг 5, 12 дугаар сард олгоно.



Гурав. Бусад зүйл

3.1. Тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн талаархи мэдээллийг Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын вэб сайтад байршуулна.

3.2. Нэрэмжит тэтгэлэг авсан оюутан өмнөхөөс өөр шалгуураар тэтгэлгийн болзол хангасан бол дахин нэг удаа нэр дэвших эрхтэй.

3.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг нэг суралцагчид давхардуулан олгохгүй.

3.4. Олон улсын хэмжээний спорт, урлагийн арга хэмжээнд амжилттай оролцож, холбогдох журмын дагуу Засгийн газраас мөнгөн шагнал авсан суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

3.5. Тэтгэлэг авагч нь худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, сургуулиас хасагдсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.6. Шалгаруулалтын явцад гарсан маргааныг холбогдох хяналтын байгууллага хянан шийдвэрлэнэ.

Засгийн газрын 2014 оны 111 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН
ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ НЭР
ДЭВШИГЧИЙН МЭДҮҮЛЭГ”-ИЙН ЗАГВАР

Зураг
2x3

1. Ургийн овог

2. Эцэг /эх/-ийн нэр.....

3. Өөрийн нэр.....

4. Төрсөн он, сар, өдөр,



5. Үндсэн харьяалал

6. Регистрийн дугаар

7. Одоо оршин суугаа хаяг

8. Гэрийн болон гар утас, и-мэйл хаяг.....
.....

9. Суралцаж байгаа сургууль, мэргэжил, курс, голч дүн

10. Олон нийтийн сонгуульд ажил

11. Нэр дэвшиж байгаа тэтгэлгийн нэр

12. Нэрэмжит тэтгэлэгт нэр дэвших үндэслэл
.....

13. Өөр тэтгэлэг, тусламж, зээл, мөнгөн шагнал авсан эсэх
.....

14. Харилцах банкны нэр, дансны дугаар
.....

_____ (Гарын үсэг)

_____ (Он, сар, өдөр)



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 115

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын цагдаагийн газар байгуулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийслэлийн цагдаагийн газар”-ыг “Улаанбаатар хотын цагдаагийн газар” болгон өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд даалгасугай.

2. “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ын “Нэг. Цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны жишиг норматив”-д дор дурдсан нэмэлт оруулсугай:

16	Хотын цагдаагийн газар	-500000-аас доошгүй хүн амтай хотод
----	------------------------	-------------------------------------

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 4 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан заалт нэмсүгэй:



“4.1.53. Банкны салбарын ажилтны өдөр-жил бүрийн 6 дугаар сарын 2-ны өдөр”

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 4 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 129

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.2, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.2, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-д дор дурдсан 2.21, 2.22, 2.23 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

“2.21. Аймаг, нийслэл, сумын Засаг дарга нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын Төрийн сан дахь дансанд сар бүр хугацаанд нь санхүүжүүлнэ.

2.22. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн сангийн нэгдсэн мэдээлэлд бүртгэгдэн, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн иргэдийн мэдээллийг сум, хорооноос сар бүрийн 5-ны дотор авч, хянан баталгаажуулж шаардагдах санхүүжилтийн хамт гэрээт банкинд хүргүүлнэ.

2.23. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилтийг олгохдоо нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн



төрийн захиргааны төв байгууллага, арилжааны төв банктай гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.”

2. Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-д дор дурдсан 2.27, 2.28, 2.29 дэх хэсгийг нэмсүгэй:

“2.27. Аймаг, нийслэл, сумын Засаг дарга нь нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтийн зардлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын Төрийн сан дахь дансанд сар бүр хугацаанд нь санхүүжүүлнэ.

2.28. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн сангийн нэгдсэн мэдээлэлд бүртгэгдэн, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт авах эрх үүссэн иргэдийн мэдээллийг сум, хорооноос сар бүрийн 5-ны дотор авч, хянан баталгаажуулж шаардагдах санхүүжилтийн хамт гэрээт банкинд хүргүүлнэ.

2.29. Нийгмийн халамжийн сангаас тусламж, хөнгөлөлтийн санхүүжилтийг олгохдоо нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, арилжааны төв банктай гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.”

3. Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-д дор дурдсан 2.28, 2.29, 2.30 дахь хэсгийг нэмсүгэй:

“2.28. Аймаг, нийслэл, сумын Засаг дарга нь нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтийн зардлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын Төрийн сан дахь дансанд сар бүр хугацаанд нь санхүүжүүлнэ.

2.29. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн сангийн нэгдсэн мэдээлэлд бүртгэгдэн, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт авах эрх үүссэн иргэдийн мэдээллийг сум, хорооноос сар бүрийн 5-ны дотор авч, хянан баталгаажуулж шаардагдах санхүүжилтийн хамт гэрээт банкинд хүргүүлнэ.



2.30. Нийгмийн халамжийн сангаас тусламж, хөнгөлөлтийн санхүүжилтийг олгохдоо нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, арилжааны төв банктай гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.”

4. Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.9 дэх хэсэг болон мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.14, 2.16, 2.20 дахь хэсгийн “нийтийн” гэсний дараа “болон агаарын” гэж тус тус нэмсүгэй.

5. Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.6 дахь хэсгийн “өөрөө сонгосон байгууллагаас авна” гэснийг “нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагаас өөрөө сонгож авна” гэж, мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.9 дэх хэсгийн “өөрийн сонгосон байгууллагаас авна” гэснийг “нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагаас өөрөө сонгож авна” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 4 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 130

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-ын 2 дугаар зүйлд дор дурдсан 2.21 дэх хэсэг нэмсүгэй:



“2.21. Энэхүү журмын 2.2-т заасны дагуу иргэн хүүхдийн мөнгө авах хүсэлтээ гаргасан боловч хүүхдийн мөнгө нь тухайн ондоо багтан дансанд нь ороогүй тохиолдолд дараа оны төсвөөс нөхөн олгоно.”

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003